Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 11 дүгээр сарын 15

| Зорилт | Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин (жилийн эцэс) | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **Стратегийн төлөвлөгөөний зорилго:** *Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж хүн амын дундаж наслалт 2019 онд 74,03 байсныг 2025 онд 75,0-д хүргэнэ.* | | | | | | | | |
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | |
| Зорилт 1.1 | | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг 95-аас дээш хувьд хүргэж ажиллана. | УТХО 2,914,3, Хандив 1421,6, ЭМДС 5,077,4, ОНХС 429,8 | Хэрэгжилтийн дундаж хувь | 91.4 | 95,0 | Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 2021-2024 оны хэрэгжилт 92,7, хууль тогтоомжийн хэрэгжилт 100, АЗДТГ-ын төлөвлөгөөнд орсон эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 95,5 , Улсын жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100, ЗГҮА-ын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт 100, АЗД-ын захирамжийн хэрэгжилт 100, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт 81.2, эдийн засаг нийгмийн үзүүлэлт 91,7% ба дундаж хэрэгжилт 96,4 хувьтай байна. | 100 |
| Арга хэмжээ | 1.1.1 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн хэрэгжилт үр дүнг тооцох. | УТХО 1151,3 Хандив 1054,2 ДЭМБ 74,4 ЭМДС 5003,0 ОНХС 299,0 | Заалтын хэрэгжилтийн дундаж хувь | 83,2 | 98,0 | 2021-2024 оны аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн төлөвлөгөөг 2 зорилго, 5 зорилт, 1 дэд зорилт, 21 арга хэмжээг төлөвлөсөн ба зорилт 96,1, арга хэмжээ 92,7 хувьтай хэрэгжсэн байна. Заалтын хэрэгжилтийн дундаж хувь 97,2 байна. | 94,6 |
| | 1.1.2 | Байгууллагад хамааралтай хууль тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэн ажиллах | ЭМДС 5003,0 УТХО 69,1 | Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 95,0 | 98,0 | Байгууллагад хууль тогтоомж шийдвэрийн эрүүл мэндийн салбарт хамааралтай Засгийн газрын тогтоол 3, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 3, АЗД-ын захирамж 2-ийг тус тус хяналтад авч эхний 10 сарын байдлаар 100 хувийн хэрэгжилттэй байна. | |
| | 1.1.3 | Аймгийн Засаг даргын тамгын газрын стратеги төлөвлөгөөнд Эрүүл мэндийн салбараас орсон заалтуудын хэрэгжилтийг гаргах. | УТХО 1207,4, Хандив 370,5, ОНХС 130,8 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 91,1 | 97,0 | Аймгийн Засаг даргын тамгын газрын стратеги төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Хэрэгжилт 95,5 | 100 |
| | 1.1.4 | Эрүүл мэндийн салбарт 2024 оныг "Эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах" төлөвлөгөөг гаргаж батлуулан хэрэгжилтийг хангах ажиллах. | УТХО 486,9 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 98,0 | 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тушаалаар 2024 оныг "Эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах жил "болгон зарласан.<br>Эх, хүүхдийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах 8 зорилт 44 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан эрүүл мэндийн газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 95,4 хувьтай байна | 97,3 |
| | 1.1.5 | Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажиллах. | - | Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 89,5 | 95,0 | Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн 5 заалт бүхий зөвлөмжийн дагуу 16 арга хэмжээг төлөвлөн батлуулж, зөвлөмжийн хэрэгжилт 98,2 хувьтай байна. | 100 |
| | 1.1.6 | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцож, дүгнэлт хийх. | - | Үзүүлэлтийн хэрэгжилтийн хувь | 47,5 | 75,0 | Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн хөгжлийн үзлүүлэлтэд нийт 11 заалтыг батлуулан эхний 10 сарын байдлаар 2 удаа дүгнэлт хийж ЭМГ-ын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж цаашид авах арга хэмжээг үүрэгжүүллээ. Эхний 10 сарын байдлаар 91,7 хувьтай болж урьд оны мөн үеэс 44,4 хувиар өссөн байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.6-д Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцож, дүгнэлт хийх арга хэмжээг төлөвлөж хэлтсийн даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусгав. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1.2 | | Хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлт 2023 онд 93,1 хувь байсныг 2024 онд 93.6 хувьд хүргэнэ. | УТХО 5,468,9, Хандив 683,0, ОНХС 683,9 | Хэрэглэгчийн үнэлгээний хувь | 93,1 | 93,6 | Нийт 1790 үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу QR код уншуулан иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч байна. 2024 оны 1 сараас эхлэн нийт эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд OR код уншуулан үнэлгээ авдаг болсон. 2021 онд 93.0 хувь байсан бол 2024 оны эхний 10 сарын байдлаар 93.5 хувьтай болж сайн үзүүлэлт 1.4 хувиар өссөн байна. | 100 |
| Арга хэмжээ | 1.2.1 | 3 сумын эрүүл мэндийн төвийг Мобайл технологиор хангах. | Хандив тусламж 76.8 | Мобайл технологиор хангасан сумын тоо | 11 | 3 | Эрдэнэдалай, Гурвансайхан, Хулд, Луус, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдэд ДЭМБ-ын санхүүжилтээр мобайль технологиор хангагдсан. Ингэснээр өссөн дүнгээр 15 сумын эрүүл мэндийн төвийн мобайль технологиор боллоо. | 100 |
| | 1.2.2. | Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийг стандартад нийцсэн вакум өрөөтэй болгох. | УТХО 1400,0 | Өрөөтэй болсон эсэх (Тийм-1, Үгүй-2) | 0 | 1 | 2024 оны 5 дугаар сард “Турнинг” ХХК-тай гэрээ байгуулж 19,9 сая төгрөгөөр ажлын зураг гарсан. Вакум өрөөг хийх бэлтгэл ажил 100 хувь хангагдсан. Үүний дагуу тендер зарлагдсан. | 100 |
| | 1.2.3 | Автомашинд сууриласан нүүдлийн клиниктэй болсон байх. | УТХО 1000,0 | Клиниктэй болсон эсэх (Тийм 1, Үгүй-2) | 0 | 1 | “Сүвэн уул” ХХК тендерт шалгарч гэрээ байгуулсан бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, иж бүрэн нүүдлийн клиниктэй болно. | 100 |
| | 1.2.4 | Дэрэн сумын эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барьж эхлэх. | УТХО 500,0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | 0 | 30 | Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг барих тендер зарлагдаад шалгаруулах шатандаа явж байна. | ҮБ |
| | 1.2.5 | Өлзийтмандал өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилгад засвар хийх. | ОНХС 74,9 | Засварын ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Өлзийтмандал өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын дээврийн төмөр, коридорын хэсэг засагдаж дууссан. Засварын гүйцэтгэл 100 хувьтай байна. | 100 |
| | 1.2.6 | Боржгонмандал өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын өргөтглийг шинээр барих | УТХО 299,0 | Барилгын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | 2024 онд Боржгонмандал өрхийн эрүүл мэндийн төвд 299,0 сая төгрөгийн цэвэр бохирын холболт хийгдсэн. Өргөтгөлийн ажил 2025 онд хийгдэхээр хойшилсон. | ҮБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.2.7 | Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн амбулаторийн цэвэр бохир усны засварын ажлыг хийх. | УТХО 109,1 ОНХС 80,4 | Засварын ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн амбулаторийн цэвэр бохир усны засварын ажил бүрэн хийгдлээ. Засвыр ажлын гүйцэтгэл 100 хувь | 100 |
| | 1.2.8 | Луус сумын эрүүл мэндийн төвийн барилгад засвар хийх. | ОНХС 110,0 | Засварын ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | “Язгуур өргөө” ХХК тендерт шалгарч Луус сумын эрүүл мэндийн төвийн туслах барилгын дээврийн засвар, гадна пасад, дотор хойд талын 4 өрөөний хана тааз, бүх цонх гээд бүтэн барилгын засварт, нийт 110,0 сая төгрөгийн ажил 100 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн. | 100 |
| | 1.2.9 | Сумдын эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах. | ОНХС 130.8 | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 85,9 | 86,7 | Орон нутгийн хөгжлийн сангийн 130,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Сумдын Эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж” нийлүүлэх гэрээний дагуу Мехатроник ХХК-тай байгуулсан гэрээгээр Эхо аппарат /зөөврийн/,12 сувагтай зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, биохимийн хагас автомат анализатор, гематологийн анализатор аппарат, хяналтын монитор, дефибрилятор зэрэг 15 нэр төрлийн, 24 ширхэг тоног төхөөрөмжийг сумдын эрүүл мэндийн төвүүдэд олголоо. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 92.1 хувьтай байна. | 100 |
| | 1.2.10 | Нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж болох гал тогоо, угаалга ариутгал, мэс заслын багаж хэрэгсэл, ухаалаг дэлгэцээр хангах | ОНХС 231,5 | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 94,2 | 95,0 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж болох гал тогоо, угаалга ариутгал, мэс заслын багаж хэрэгсэл, ухаалаг дэлгэц зэрэг 4 багц тоног төхөөрөмж 100 хувьтай хангагдлаа. Тоног төхөөрөмжийн хангалтын хувь 95,2 | 100 |
| | 1.2.11 | Эрүүл мэндийн байгууллагуудыг хог хаягдлын автоклаваар хангах. | Хандив 396,2 | Автоклаваар хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо | 17 | 3 | Нийт 15 сум, 2 өрхийн эрүүл мэндийн төв, уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгүүд 2023 онд 100 хувь хог хаягдлын автоклаваар хангагдсан. Аймгийн нэгдсэн эмнэлэг болон Зоонозын өвчин судлалын төвд НҮБ-ын Хүүхдийн сангийн 396.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар STERIPLUS-40 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | маркийн хог хаягдлын автоклаваар тус тус хангагдлаа. Ингэснээр эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд хог хаягдлыг бүрэн ариутгалд оруулж аюулгүй байдал хангагдлаа. | |
| | 1.2.12 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай тусламжийн зөөврийн тоног төхөөрөмжөөр хангах | УТХО 44,9 | Яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 47,0 | 48,0 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламжийн болон гамшгийн бэлэн байдлыг хангах зорилгоор 8 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангалаа. Яаралтай тоног төхөөрөмжийн хангалт 79.5 хувьтай байна. | 100 |
| | | | УТХО 578,9 | Тоноглосон тоо | 4 | 1 | Улсын төсвийн 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өлзийт сумын эрүүл мэндийн төвд ЛАНД 78 маркын автомашин, аймгийн нэгдсэн эмнэлэгт 538,9 сая төгрөгийн MAN TGE 3.180 маркын автомашиныг бүрэн тоноглосон Тоноглосон автомашин 2 өссөн дүнгээр 6 боллоо. | |
| | | | УТХО 1552,7 | Машины хангалтын хувь | 94,0 | 95,0 | Улсын төсвийн 1552.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өлзийт, Цагаандэлгэр, Эрдэнэдалай, Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвд ЛАНД 78 маркын автомашин, Сайхан овоо, Өндөршил сумын эрүүл мэндийн төвд HIACE маркын автомашин, аймгийн Нэгдсэн эмнэлэгт MANTGE-3180 маркын автомашин, Говьугтаал сумын эрүүл мэндийн төвд Probox маркийн автомашиныг тус тус хүлээлгэн өгч яаралтай түргэн тусламжийн бэлэн байдлыг хангалаа. 2021-2024 оны хооронд Эрүүл мэндийн салбарт 44.2 хувьд автомашины парк шинэчлэлт хийлээ. Автомашин хангалт 98.0 хувьтай болж 4 хувиар өссөн байна. | |
| | 1.2.13 | Алслагдсан сум болох Баянжаргалан сумын эрүүл мэндийн төвийг түшиглэн Яаралтай тусламжийн цэг байгуулах. | ОНХС 56,2 | Яаралтай тусламжийн цэгийн тоо | 4 | 1 | Сайнцагаан сумаар дамжин өнгөрөх Автозамын пост, Хулд, Дэлгэрцогт, Луус, Сайхан-Овоо, Баянжаргалан сумдын эрүүл мэндийн төвийг түшиглэсэн яаралтай тусламжийн цэгийг байгууллаа. Тус цэгүүдээр зам тээврийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | осол 45, бусдад зодуулсан 8, уналт 16, хурц иртэй зүйлд зүсэгдсэн 15, осголт 1, түлэгдэлт 6, хордлого 25, амьтанд хазуулсан 7 тус тус чиглэлээр нийт 123 хүнд анхан шатны тусламжийг үзүүллээ. Сайхан-Овоо, Баянжаргалан сумдын эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламжийн 6 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө. Ингэснээр 6 сумын эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн яаралтай тусламжийн цэгийг байгуулан яаралтай тусламжийн тоног төхөөөрөмжийн хангалт 79,5 хувьд хүрсэн. | |
| | 1.2.14 | Өлзийт сумын эрүүл мэндийн төвийг уламжлалт анагаах ухааны чиглэлээр жишиг өрөөтэй болгох | Хандив 10,0 | Өрөөтэй болсон эсэх (Тийм 1, Үгүй 2) | 0 | 1 | Уламжлалт ангаах ухааны зөвлөх их эмч Л.Бямбаагийн хувийн санхүүжилтээр Өлзийт сумын эрүүл мэндийн төвд уламжлалт анагаах ухааны жишиг өрөөг байгууллаа. | 100 |
| | | | | Тусламж үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо | 0 | 50 | Зэс бумба, хүчил төрөгч өтгөрүүлэгч, уламжлалт анагаах ухааны эмчилгээнд хэрэглэгдэх тоног төхөөрөмжүүдийг байршуулсан. Уламжлалт анагаах ухааны жишиг өрөөтэй болсноох эхний 10 сарын байдлаар 86 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг, уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээг үзүүлсэн байна. | |
| | 1.2.15 | Нэгдсэн эмнэлэг болон сумдын эрүүл мэндийн төвүүдийн эхчүүдийн амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах | УТХО 10,0 | Орчин нөхцөл сайжирсан эхийн амрах байрны хувь | 50,0 | 55,0 | Эхчүүдийн амрах нөхцөл хангагдсан амрах байртай эрүүл мэндийн байгууллага нь аймгийн Нэгдсэн эмнэлэг, Баянжаргалан, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Адаацаг, Сайхан-Овоо, Хулд, Өлзийт сумдууд байна. 2024 онд эхийн амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах төслийн эрүүл мэндийн төвүүдийн эх барих эмч нар боловсруулан сумын Засаг даргын тамгын газарт орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлүүлэхээр хүргүүлээд байна. Эмнэлгүүд өөрсдийн нөөц боломжоор тохижилт хийсэн бөгөөд зурагт,хивс,ус | 83 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | буцалгагч зэрэг хэрэгжээт зүйлсээр хангаж 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Орчин нөхцөл сайжирсан эхийн амрах байрны хувь 53,3 байна. | |
| | | | | Эхийн амрах байраар амарсан эхийн тоо | 285 | 150 | Аймгийн хэмжээнд нийт 248 жирэмсэн эх жирэмсний хяналтад бүртгэгдэж хожуу хяналтад 7 эх орж, жирэмсний эрт хяналт 96.4 хувьтай байна. Эхний 10 сарын байдлаар нийт 44 эх амарч, өссөн дүнгээр 329 эх болсон байна. | |
| | 1.2.16 | Дэлгэрцогт эрүүл мэндийн төвийн барилгын дотор талд их засвар хийх. | Хандив 200,0 | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 | Дэлгэрцогт сумын эрүүл мэндийн төв нь М-Си-Эс группын хандив тусламжаар 200.0 сая төгрөгөөр дотор талын их засвар хийлээ. Ингэснээр үйлчлүүлэгчдийн ээлтэй орчин бүрдсэн. Гүйцэтгэл 100 хувьтай. | 100 |
| Зорилт 1.3 | | Эмийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн худалдан авалтыг эрчимжүүлэн ажиллана. | Бусад 200,0, УТХО 17,2 | Бодлого шийдвэрийн хувь | 80 | 95 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвийн зайлшгүй шаардлагатай болон амин чухал эм, эмнэлгийн хэрэгсэлд 44 багцийг Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах хуулийн дагуу тендер зарлан сонгон шалгаруулж худалдан авч хүртээмжийг нэмэгдүүлж байна. Бодлого шийдвэрийн хэрэгжилтийн хувь 97,3 | 100 |
| Арга хэмжээ | 1.3.1 | Эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг оновчтой тооцон худалдан авах ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, ерөнхий гэрээгээр худалдан авч байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг өөр эх сурвалжаас авахгүй байх | Тендер буюу бусад 200,0 | Худалдан авсан эмийн хангалтын хувь | 100 | 100 | Эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг оновчтой тооцон худалдан авах нээлттэй тендерээр нийт 16 багцаар тендер зарлаж 5 компани 14 багцад санал ирүүлэн шалгаруулалтын шатанд явж байна. Ерөнхий гэрээгээр 114 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл сумдуудаас захиалгыг авч худалдан авалтын эмийн хангалт 100 хувьтай байна. | 100 |
| | | | | Өөр эх сурвалжаас авсан эсэх (Үгүй 2, Тийм 1) | 2 | 2 | Өөр эх сурвалжаас авсан байхгүй байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.3.2 | Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтыг сайжруулж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх. | УТХО 17,2 | Зайлшгүй болон амин чухал эмийн хангалтын хувь | 89.5 | 90,0 | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/197 дугаар тушаалаар зайлшгүй шаардлагатай эм, 2009 оны 388 дуугаар тушаалаар амин чухал эмийн хангалтыг тус тус баталсан. Эмийн сангуудад орион фарм эмийн программ ашигласнаар эмийн бар код, хугацаа, эмийн өртөг, жижиглэн үнэ, ангилал, хөнгөлөлттэй эмийн олголт, жортой, жоргүй эмийн олголт эмийн чанар аюулгүй байдалд дотоод хяналт байнга хийгдэж байна. Зайлшгүй болон амин чухал эмийн хангалтын хувь 89,7 | 100 |
| | | | | Төлбөрийг нь төр хариуцдаг эмийн гүйцэтгэлийн хувь | 86.0 | 88.0 | Төлбөрийг нь төр хариуцах эмийн батлагдсан төсөв 24,591,800 төгрөг байна. Эхний 10 сарын байдлаар байдлаар 7 төрлийн оношоор 583 хүнд 17,171,144 төгрөгийн төлбөрийг нь төр хариуцах эмээр үйлчилсэн. Эмчийн бичсэн жорын дагуу төлбөрийг төр хариуцах эмийг шаардлагатай хүмүүст зохиох журмын дагуу 100 хувь олгож ажиллалаа. | |
| **Зорилт** 1.4 | | Явцын болон гүйцэтгэлийн хяналт шинжилгээ үнэлгээнд эрүүл мэндийн байгууллагуудын 80 хувийг хамруулна. | УТХО 22,6 | Хамрагдалтын хувь | 70,0 | 80 | Явцын болон гүйцэтгэлийн хяналт шинжилгээ үнэлгээг хагас бүтэн жилээр 2 удаа зохион байгуулж, нийт эрүүл мэндийн байгуллагуудын 83,3 хувьд хийлээ. | 100 |
| Арга хэмжээ | 1.4.1 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн 2023 оны жилийн эцсийн ажлыг дүгнэж, зөвлөгөөн зохион байгуулах | - | 2023 оны жилийн ажлын гүйцэтгэлийн хувь | 88,9 | 90-ээс дээш | Аймгийн эрүүл мэндийн салбарын 2023 жилийн эцсийн ажлыг дүгнэж, удирдах ажилтнуудын зөвлөгөөнийг зохион байгууллаа. 2023 оны жилийн эцсийн үнэлгээгээр 90-100 хувийн үнэлгээтэй 3, 80-89 хувьтай 5, 70-79 хувьтай 12 эрүүл мэндийн байгууллагууд байна. Оны жилийн эцсийн үнэлгээгээр Сайнцагаан сумын эрүүл мэндийн төв, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, Зооноз өвчин судлалын төв, Боржгонмандал, Өлзийтмандал өрхийн эрүүл мэндийн төвүүд шалгарсан. Жилийн эцсийн гүйцэтгэлийн хувь 89,5 | 54,5 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.4.2 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, зөвлөн туслаж ажиллах. | УТХО 6,3 | Хяналт үнэлгээ хийсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | 17 | 10 | Явцын хяналт шинжилгээ үнэлгээг сумын 14 сумын эрүүл мэндийн төв, аймгийн Нэгдсэн эмнэлэгт хийлээ. Хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо 15 | 100 |
| | | | | Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 85,0 | 93,0 | Явцын шалгалтаар илэрсэн дутгалуудыг хуагцаатай зөвлөмж болгон өглөө. Зөвлөмжийг 7 дугаар сар болон 11 дүгээр сард авахаар төлөвлөж зөвлөмжийн хэрэгжилт 94,7 хувьтай байна. | |
| | 1.4.3 | Эрүүл мэндийн 6 байгууллагыг магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу явцын хяналт хийж, магадлан итгэмжлэлд хамруулах | УТХО 12,3 | Хамрагдсан байгууллагын тоо | 8 | 6 | 2024 онд магадлан итгэмжлэлд хамрагдах 6 эрүүл мэндийн төв, 2025 онд орох 3 эрүүл мэндийн төвүүдээр магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу урьдчилсан үнэлгээ хийлээ. | 100 |
| | | | | Магадлангийн үнэлгээний урьдчилсан дүнгийн хувь | 55 | 85 | 2024 онд магадлан итгэмжлэлд орох 6 эрүүл мэндийн төвд Эрүүл мэндий газрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг магадлан итгэмжлэлийн урьдчилсан явцын хяналт үнэлгээг хийж зөвлөн тусалж ажилласан. Явцын хяналт шинжилгээ үнэлгээгээр дутагдалтай байсан ажлыг 100 хувь болгон хэрэгжүүлэх хугацаатай үүрэг чиглэл өгч ажилласны үр дүнд эмнэлгүүд амжилттай магадлан итгэмжлэгдлээ | |
| | | | | Магадлан итгэмжлэлд хамруулсан эсэх (Тийм 1, Үгүй 2) | 2 | 1 | Дэлгэрцогт, Дэрэн, Говьугтаал, Өндөршил сумдын эрүүл мэндийн төв тус бүр 2 жилээр Хулд, Цагаандэлгэр сумдын эрүүл мнэдийн төв тус бүр 3 жилээр 100 хувь амжилттай магадлан итгэмжлэгдлээ. | |
| | 1.4.4 | Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулан, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавин ажиллах. | - | Гэрээ байгуулсан өрхийн тоо | 2 | 2 | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 сарын 15-ны 122 дугаар тушаалд заасны дагуу Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, 2 өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар хамтран гүйцэтгэлийн гэрээг байгууллаа.<br>Гэрээ байгуулсан Өрхийн эрүүл мэндийн тоо -2 | 66,6 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Гүйцэтгэлийн хувь | 90 | 93,0 | Аймгийн Засаг дарга, Боржигонмандал, Өлзийтмандал өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, Эрүүл мэндийн газрын даргатай гурвалсан гэрээг Эрүүл мэндийн сайдын шинэчлэн баталсан 2024 оны 122 дугаар тушаалын дагуу байгууллаа. Гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар Боржгонмандал өрхийн эрүүл мэндийн төв 82,4, Өлзийтмандал өрхийн эрүүл мэндийн төв 94,5 хувьтай тус тус дүгнэгдлээ. Гэрээний дундаж хэрэгжилтийн хувь 88,5 | |
| | | | | Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 90,0 | 91,0 | Гэрээг дүгнэн хугацаатай үүрэг өгч, зөвлөмж хүргүүлснээр зөвлөмжийн хэрэгжилт 92,3 хувьтай байна. | |
| | 1.4.5 | 9 сумын эрүүл мэндийн төвүүдэд Зоонозын халдварын үед ажиллах бэлэн байдалд дэмжлэгт хяналт хийж зөвлөн туслаж ажиллах. | УТХО 4,0 | Дэмжлэгт хяналт хийсэн тоо | 5 | 9 | 9 сумын эрүүл мэндийн төвийн зоонозын халдварын үед ажиллах бэлэн байдалд дэмжлэгт хяналт хийж, 113 эмч, ажилтан мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн 385, нийт 498 хүнийг зоонозын халдварын үед ажиллах талаар мэргэжил арга зүйгээр хангасан. Дэмжлэгт хяналтын үед илэрсэн дутагдлыг арилгахаар 8 заалттай зөвлөмжийг хүргүүлсэн. | 100 |
| | | | | Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 60 | 90 | Дэмжлэгт хяналтаар илэрсэн дутагдлыг арилгуулахаар 8 заалттай зөвлөмж хүргүүлсэн. Нийтлэг илэрч буй зөрчлүүд гамшгийн төлөвлөгөөнд тодотгол хийгээгүй, иргэдэд чиглэсэн зоонозын халдварын талаар сургалт сурталчилгаа тогтмол хийдэггүй, тарваган тахлын бэлэн байдлыг хангаж асуумж судалгааны хуудсыг хэвлэж бэлтгээгүй, дуудлагаар ажиллах эмчийн биксэнд 1 удаагийн амны хаалт хийгээгүй, бэлэн байдлыг хангаж агуулахыг эмхлэж цэгцлээгүй зэрэг дутагдлууд түгээмэл илэрч байна. Эдгээр дутагдлыг арилгуулахаар 30 хоногийн хугацаатай зөвлөмжийг хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 90.3 хувь байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт** 1.5 | | Эхийн эндэгдэлгүй ажиллаж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 3,3 промилиор бууруулна. | УТХО 16,5 | Эхийн эндэгдлийн түвшин (100000 амьд төрөлтөд) | 0 | 0 | Эхний 10 сарын байдлаар нийт 467 эх төрж, амьд төрөлт 468 бүртгэгдсэн. Нийт төрсөн эхчүүдийн 96,3 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтад төрсөн байна. Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна. | 100 |
| | | | | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг түвшин (1000 амьд төрөлтөд) | 14,5 | 12,2 | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин өнгөрсөн оны мөн үед 12,0 промиль байсан бөгөөд эхний 10 сарын байдлаар 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 тохиолдол бүртгэгдэж 4,3 болж 7,7-оор буурсан байна. | |
| | | | | Сурфактант эмчилгээ хийсэн тоо | 2 | 5 | 2024 онд дутуу төрсөн 7 нярайд сурфактант эмчилгээ хийж 100 хувь үр дүнтэй болсон | |
| Арга хэмжээ | 1.5.1 | Жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтыг сайжруулах зорилгоор “Ээлтэй тусламж-Эсэн мэнд амаржихуй” 3 сарын аянг зохион байгуулах. | УТХО 2,0 | Жирэмсний эрт хяналтын хувь | 91,3 | 94,6 | Эхний 10 сарын байдлаар нийт 443 эх хяналтанд орсноос 430 эх эрт, 13 эх хожуу хяналтад орж жирэмсний эрт үеийн хяналт 97,1 хувь болж өнгөрсөн оны мөн үеэс 6,1 хувиар өссөн. | 100 |
| | | | | Аяны хэрэгжилтийн хувь | 0 | 95 | Эх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах жилийн хүрээнд эх барихын аяны тайланг авч дүгнэсэн бөгөөд хэрэгжилт 95,2 хувь байна. Аяны хүрээнд Өндөршил, Хулд, Гурвансайхан сумын эрүүл мэндийн төвүүд эхний 3 байранд шалгарсан. | |
| | 1.5.2 | Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шаардлагатай арга хэмжээ хэрэгжүүлж ажиллах. | - | Тайланг АЗД-ын зөвлөлөөр хэлэлцүүлсэн тоо | 0 | 2 | Эх, хүүхдийн нөхөн үржихүйн арга хэмжээний тайланг нэгтгэн дүгнэж аймгийн засаг даргын зөвлөлд албан бичгээр хүргүүлж хэлэлцүүлсэн. | 100 |
| | | | | Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 0 | 92 | Эмнэлэг эрүүл мэндийн төвүүдэд зөвлөмж хүргүүлж хэрэгжилт 93 хувьтай байна | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.5.3 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтэд улирал бүр дүгнэлт хийж сайжруулах арга хэмжээ авч ажиллах. | - | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн хувь | 70,0 | 76,0 | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт 81,2 хувьтай байгаа бөгөөд зорилтот түвшингээс 5,4 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 10,8 хувиар тус тус өссөн байна. Сүрьеэгийн өвчлөл нэмэгдэж, чихрийн шижин хэв шинж-2, Артерийн гипертензийн эрт илрүүлэг өссөн байна. | 80 |
| | | | | Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин (10 000 хүн амд) | 20,0 | 21,1 | Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин 10 000 хүн амд 18,6 хувьтай байна. | |
| | | | | Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин (10 000 хүн амд) | 14,1 | 13,1 | 2024 оны 10 сарын байдлаар 61 хавдрын шинэ тохиолдол бүртгэгдэж 27,8 хувийг эрт үедээ оношилсон. Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин 10 000 хүн амд 8,8 хувийг эзэлж байна. | |
| | | | | 0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин (10000 хүүхдэд) | 28,7 | 27,0 | 10000 хүүхдэд 0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин 5,1 промиль байна. Түлэгдлийн 80 хувь гэр ахуйн орчинд түлэгдсэн түлэгдэл бүртгэгдэж байгаа нь иргэдийн хүүхдэдээ тавих анхаарал, халамж дутуу байгаатай холбоотой байна. | |
| | | | | Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин (10 000 хүн амд) | 3.0 | 0,5 | Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин 10 000 хүн амд 1,5 промиль байна. Энэ дотроо угаарын хийн хордлого 57,1 хувь эзэлж байна. | |
| | 1.5.4 | Эрүүл мэндийн сайдын 2015 оны 495 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн газрын дэргэдэх сувилахуй, тусгай | УТХО 1,9 | Алба байгуулсан эсэх (Тийм 1, Үгүй 2) | 2 | 1 | Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/20 дугаар тушаалаар “Сувилахуй, тусгай мэргэжилтний алба”-ыг 7 хүний бүрэлдэхүүнтэй томилсон. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэргэжлийн тусламж үйлчилгээний алба байгуулж, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 0 | 95,0 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд сувилахуйн тусламж, үйлчилгээ болон Эрүүл мэндийн газрын дэргэдэх салбар зөвлөлийн төлөвлөгөө 95,5 хувийн хэрэгжилттэй байна. | |
| | | | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | 4 | Эрүүл мэндийн байгууллагуудад 8 удаа сургалт, 3 арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 755 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд хамрагдлаа. Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд 4 багц цаг, бусад мэргэжилтнүүдэд 5 багц цагийн сургалтыг зохион байгуулж багц цагийг бүрдүүлээд байна. Зохион байгуулсан сургалтын тоо 8 | |
| **Зорилт** 1.6 | | Цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлнэ. | ДЭМБ 74.4 УТХО 405,7 Хандив 527.1 | Нэмэгдсэн санхүүжилтийн хэмжээ (сая.төг) | 2347,0 | 1000,0 | Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд 1007,2 сая төгрөгийн санхүүжилт авсан. | 100 |
| **Арга хэмжээ** | 1.6.1 | Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах. | Хандив тусламж 92,6, УТХО 48,8 | Гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 85,0 | 90,0 | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 79,9 сая төгрөгийн санхүүжилтээр шатахууны зардал болон 68 багийн эмчийн багц цүнх, Улсын төсвөөр 48,8 сая төгрөгний шатахууны зардал болон Өлзийт, Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Цагаандэлгэр сумдад бүлээцүүлэх хөнжил болон термостат, НҮБ-ын Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар 3.4 сая төгрөгийн хоол тэжээл багц, Велл бии ХХК -аас 9.3 сая төгрөгийн иргэдийн дархлаажуулалт дэмжих эм бэлдмэлийн тус тус олголоо.<br>Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211-“Жагсаалт батлах тухай” тушаалаар батлагдсан 18 нэр төрлийн тоног төхөөрөмжийн хангалт 91,3 хувьтай байгаа нь эхний хагас жилээс 0,6 хувиар өссөн байна. | 100 |
| | | | | Гамшгийн үеийн эм, эмнэлгийн | 58,0 | 60,0 | 2024 оны эхний 10 сарын байдлаар коронавирусын халдварын тохиолдол бүртгэгдээгүй байна. Томуугийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэгсэлийн нөөцийн хангалтын хувь | | | харуулдан тандалтын тогтолцоогоор 2024 оны 44 дэх 7 хоногийн байдлаар амбулаторийн үзлэгт 6.4%, дуудлагын үзлэгт 17.0 %-тай томуу, томуу төст өвчлөлийн тархалт "Идэвхжлийн түвшин"-д, коронавируст халдварын тархалт "Ногоон" буюу тархалт бага/тогтвортой" түвшинд байна.. 2024/2025 оны томуугийн улирал эхэлсээр одоогоор риновирус, амьсгалын синцитиаль вирус, иж томуугийн вирус, аденовирус тус тус эргэлтэд байна. Гамшгийн үеийн нийт 107 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалт 90,7 хувьтай байна. | |
| | | | | Бэлэн байдлыг хангуулсан зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 60 | 90,0 | Эрүүл мэндийн газрын даргын А/80 дугаар тушаалаар "Өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах тухай" 14 хэрэгжүүлэх үйл ажиллагааг бүхий төлөвлөгөөг эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 90,5 хувьтай байна. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч Эрүүл мэндийн газраас цаг үеийн нөхцөл байдлын цахим хурлыг 7 удаа зохион байгуулж зөвлөн тусалж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 85,0 хувьтай байна. | |
| | 1.6.2 | Гамшгийн үед ажиллах мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах. | УТХО 3,8 | Сурган дадлагажуулсан бүрэлдэхүүний тоо | 55 | 55 | Гамшгаас хамгаалах хуулийн 32 дугаар зүйлийн 32,1 дэх заалт , Монгол улсын засгийн газрын 2011 оны 339, 340 тогтоолын дагуу газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдлыг хангах зарлан мэдээллэх дохиоллоор ажиллах дадлага сургуулилтад Эрүүл мэндийн албаны штаб, мэргэжлийн ангиуд болон эмнэлгийн ажилчид нийт 93 , Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр "Гамшгийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үеийн хариу арга хэмжээний хүрээнд нялх, бага насны хүүхдийн хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх” сэдэвт сургалтад 21 багийн эмч нарыг хамруулсан. Нийт сурган дадлагажуулсан бүрэлдэхүүний тоо 114. | |
| | | | | Сурган дадлагажуулсан мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний тоо | 58 | 60 | Гамшгийн үеийн сэтгэц-нийгмийн дэмжлэг үзүүлэх” говийн бүсийн бүсчилсэн танхимын сургалтад 20 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Осголт, хөлдөлтийн үед авах арга хэмжээ, Угаарын хийн хордлогын үеийн эмнэлзүй, авах арга хэмжээ цахим сургалтад 45 эмч, эмнэлгийн ажилтан, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, болзошгүй цар тахлын үед хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах сургалтад 4 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг тус тус сурган дадлагажуулсан байна. Нийт 2 мэргэжлийн ангийн 69 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа. | |
| | 1.6.3 | Зоонозын халдварын үед ажиллах бэлэн байдлын чиглэлээр эмч, эмнэлгийн ажилтан болон мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулах. | УТХО 0,3 | Сургалтад хамрагдсан эмч ажлтан, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний тоо | 75 | 90 | Зоонозын халдварын үед ажиллах бэлэн байдлын хангах, хариу арга хэмжээ авах сургалтыг 5 сумын 62 эмч, эмнэлгийн ажилтан, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн нийт 192 хүнд 6 удаа сургалт зохион байгууллаа | 100 |
| | 1.6.4 | Аймгийн нэгдсэн эмнэлгийн вирус судлалын лабораторит вирусийн ачаалал тоолох оношилгоог нэвтрүүлэх. | УТХО 35,0 | Шинээр нэвтрүүлсэн шинэ аргын тоо | 0 | 1 | Эрүүл мэндийн яамны 35,0 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлэгт вирусийн ачаалал тоолох, оношилуурыг худалдан авсан. Ингэснээр вирусийн ачаалал тоолох оношилгоог шинээр нэвтрүүллээ. | 64 |
| | | | | Шинжилгээний тоо | 0 | 25 | Элэгний В, С, Д вирусийн ачаалал тоолох оношилуурын худалдан авалтыг хийж вирус судлалын лабораторит нөөцийг бүрдүүлж шинжилгээг нэвтрүүлсэн. Шинжилгээг нийт 7 хүнд хийгээд байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт** 1.7 | | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, хяналтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ. | УТХО 3,4 | Эрсдэлийг бууруулсан хувь | 40 | 35 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг Эрүүл мэндийн яамны салбарын хяналт шалгалтын газрын даргын баталсан тушаал төлөвлөгөөний дагуу батлагдсан нийт 18 байгууллагад хийхэд эрсдэл хувь 33,5 хувьтай байна. | 100 |
| Арга хэмжээ | 1.7.1 | **<u>ТХШТХ-ийн 5.19, ЭМТХ-ийн 42.1, ЗГ- ын 2022 оны 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.4, 6.2</u>** Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн болон шинээр байгуулагдсан 18 эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд төлөвлөгөөт шалгалт хийх | УТХО 2,8 | Обьектын хамралтын хувь | 88 | 100 | Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 заалт Засгийн газрын 420 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Боловсрол, шинжлэх ухааны яамны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын даргын баталсан 10-00/11, 03-01/01 дугаартай нэгдсэн удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн. Эмчилгээний чанарын хяналтад 18 эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд хамрагдахаас 18 объект буюу 100% шалгалтад хамрагдсан байна. Нийт 416 дутагдал илрүүлж, 69 буюу 16.6 хувийг нь шалгалтын явцад арилгуулсан. Бусад илэрсэн дутагдлыг арилгуулахаар хугацаатай 18 албан шаардлагад 347 заалтыг тусгасан. Шалгалтаар 1 сумын эрүүл мэндийн төв их, 10 эрүүл мэндийн төв дунд, 1 сувилал, 7 эрүүл мэндийн төв бага эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн байна. Нийт 18 эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд хамрагдаж, төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан обьектын хамралтын хувь 100 байна. | 100 |
| | | | | Эрсдэлийн түвшин буурсан обьектын хувь | Их- 25.6% дунд- 62% | Их- 30% дунд- 68% | Их эрсдэлийн түвшинтэй шалгагдсан 10 объектоос 9 буюу 90 хувь нь, дунд эрсдэлийн түвшинтэй шалгагдсан. 8 объектоос 8 буюу 100 хувь нь эрсдэлийн түвшин буурсан байна. Эрсдэлийн түвшин буурсан обьектын дундаж хувь 94.4. **<u>Үүнээс:</u>** Их эрсдэлтэй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үнэлэгдэж хяналт шалгалт хийгдсэн 10 объектын 9 нь буюу 90% нь түвшин буурсан үзүүлэлттэй, дунд эрсдэлтэй үнэлэгдэж хяналт шалгалт хийгдсэн 8 объектын 8 нь буюу 100% эрсдэлийн түвшин буурсан үзүүлэлттэй байна. | |
| | | | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 71 | 75 | Нийт төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан объектын хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь 75,1 байна. | |
| | 1.7.2 | Эмнэл зүйн лабораторид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | - | Обьектын хамралтын хувь | - | 100 | Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан “Эмнэлзүйн лабораторийн тусламж үйлчилгээний чанар, био аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийн 10-00/12 дугаар бүхий удирдамжийн хүрээнд эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр 10 асуудлын хүрээнд “Мед анализ”, “Онч” хувийн лабораториудад хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар “Мед анализ”лабораторид илэрсэн зөрчил байхгүй, “Онч” лабораторид хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх, шинжилгээний нэр төрөл,тоо, ачааллыг нэмэгдүүлэх, гадаад хяналтыг сайжруулах 3 заалт бүхий албан шаардлагыг өгсөн. Тухайн шалгалтын нэгдсэн танилцуулгын ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын улсын ахлах байцаагчид хүргүүлээд байна. Обьектын хамралтын хувь-100 | 100 |
| | | | | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | - | 100 | “Онч” лаборатори лабораторийн их эмчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулсанаар шинжилгээний нэр төрөл 3-аар нэмэгдсэн байна. Албан шаардлагын хэрэгжилтийн хувь 66.6% байна. | |
| | 1.7.3 | Шүдний тусламж үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | - | Обьектын хамралтын хувь | 96.0 | 100 | Монгол Улсын Засгийн газрын “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан 2024 оны хяналт шалгалтын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлдэг шүдний эмнэлгүүдийн үйл ажиллагаанд Төрийн хяналт шалгалтын тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх шалгалт хийж, үүссэн шалтгаан нөхцөлийг тогтоох, цаашид үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж, холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх зорилгоор Салбарын хяналтын газрын даргын баталсан ”Шүдний эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” 10-00/13 дугаартай удирдамжийн дагуу 2024 оны 07 дүгээр сарын 16-ны өдрөөс 09 дүгээр сарын 20-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлдэг шүдний 5 клиник хамрагдахаас 5 клиникийг бүрэн хамруулсан. Обьектын хамралтын хувь: 100 | |
| | | | | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | - | 60 | Урьдчилан сэргийлэх шалгалтаар албан шаардлага өгөгдсөн эмнэлэг байхгүй. Хяналт шалгалтаар нүүр амны тусламж үйлчилгээний 5 байгуулагад 8 зөрчил илрүүлэн зөвлөмж өгсний дагуу зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна. | |
| | 1.7.4 | Өрхийн эрүүл мэндийн төвд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | - | Обьектын хамралтын хувь | - | 100 | Салбарын хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 420 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үүсч болох эрсдэлээс сэргийлэх, мэргэжил арга зүйгээр хангах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж, холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэхээр 2024 оны 04 дугаар сарын 12-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 2 өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд удирдамжид заагдсан эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр шалгах 8 бүлгийн 45 хяналтын асуудлаар шалгасан. Обьектын хамралтын хувь 100 | 100 |
| | | | | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | - | 60 | Хяналт шалгалтын дүнг үндэслэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор биелүүлэх хугацаатай 10-23-01/097/01-02 дугаартай 39 заалттай албан шаардлага тус тус хүргүүлсэн. Албан шаардлагын хэрэгжилтийн хувь-66 | |
| | 1.7.5 | Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | УТХО 0,65 | Обьектын хамралтын хувь | 100 | 100 | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг “Бүрдийн уянга” хүүхдийн зусланд үйл ажиллагаа эхлэхийн өмнө урьдчилан сэргийлэх шалгалтыг ХХААГ-ын хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагч Б. Түвшинтөгстэй хамтарсан урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, зөвлөгөө өгч арга зүйгээр хангаж ажилласан. Хамралтын хувь 100 | 100 |
| | | | | Зөрчил арилгуулалтын хувь | 24.7 | 25 | Хяналт шалгалтын явцад 7 зөрчил илрүүлснээс газар дээр нь 2 зөрчлийг арилгуулж 5 заалт бүхий зөвлөмжийг өгч ажилласан байна. Зөрчил арилгуулалтын хувь 28.6 | |
| | | | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 67.5 | 68 | Хууль тогтоомжийн хэрэгжилт 82,0 хувь | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.7.6 | **<u>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^{2}$.1.</u>** Иргэн, ААН, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх | - | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь | - | 100 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийгдээгүй. Улсын байцаагчид ирсэн өргөдөл гомдол бүртгэгдээгүй байна. | 100 |
| | | | | Зөрчил арилгуулалтын хувь | - | 100 | Өргөдөл гомдол бүртгэгдээгүй тул зөрчил арилгуулалт тооцогдохгүй болно. | |
| | 1.7.7 | Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар 18 объектод гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх | - | Албан шаардлагын биелэлтийн хувь | 64 | 80 | Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах болон өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар хугацаа болсон 18 объектод гүйцэтгэлийн хяналт шалгалт хийлээ. Төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан сумын эрүүл мэндийн 13 төв, өрхийн эрүүл мэндийн 1 төв, клиникийн 3 эмнэлэг, 1 сувилал тус тус хамрагдлаа.<br>Албан шаардлагын биелэлтийн хувь: 81,5 | 100 |
| | | | | Зөрчил арилгалт /хувь/ | 70 | 80 | Зөрчил арилгалтын хувь 82.8 | |
| **ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | |
| **Зорилт 2.1** | | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг 2023 онд 70,0 байсныг 2024 онд 76,0 хувьд хүргэнэ. | УТХО 64,4 | Чанарын үзүүлэлтийн хувь | 70,0 | 76,0 | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт 81,2 хувьтай байгаа бөгөөд зорилтот түвшингээс 5,4 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 10,8 хувиар тус тус өссөн байна. Сүрьеэгийн өвчлөл нэмэгдэж, чихрийн шижин хэв шинж-2, Артерийн гипертензийн эрт илрүүлэг өссөн байна**.** | 100 |
| Арга хэмжээ | 2.1.1 | Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор явуулын (мобайл) технологи ашиглан үзлэг, шинжилгээнд хамруулсан байх. | УТХО 5,3 | үзлэгт хамрагдсан хүн амын эзлэх хувь | 8,0 | **10** | 15 сумын эрүүл мэндийн төвүүдэд мобайл технологийн тоног төхөөрөмж, урвалж оношлуурыг ашиглан 18100 хүнийг эмчийн үзлэг болон лабораторийн шинжилгээнд хамрууллаа. Эхосонографийн үзлэгт 1300, ЭКГ-ийн шинжилгээнд 820, Туберкулины сорил 150, С-вирусийн тестийн шинжилгээ 1258, В-вирусийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шинжилгээ 1320, хеликобактерийн шинжилгээ 905, артерийн даралт үзүүлж үзлэгт хамрагдсан 3830, чихрийн шижингийн үзлэгт хамрагдсан 3660, цус багадалтын шинжилгээ 246, сахарын тест 2390 хүнд тус тус үзлэг хийгдлээ. Үзлэгт хамрагдсан хүн амын эзлэх хувь 37,8 | |
| | 2.2.2 | Эрүүл мэндийн сайдын 340 дугаар тушаалын дагуу албан байгуулага, аж ахуйн нэгжүүдтэй урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах гэрээ байгуулж, үзлэгт хамруулж, эрүүлжүүлэлтийг тооцож ажиллах | УТХО 5,3 | Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо | 1150 | 1200 | Албан байгууллага аж ахуйн нэгжийн албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар гэрээ хийсэн. Гэрээний дагуу 8 байгууллагын 205 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, 137 иргэнд өвчлөл илэрч, аж ахуйн нэгж, байгууллагын 404 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, нийт үзлэгт 609 иргэнийг хамрууллаа. | 50,0 |
| | | | | Эрүүлжилтийн хувь | 30.0 | 32,0 | Архаг болон цочмог өвчлөл илэрсэн 137 иргэнийг хяналтад авч, эмчилгээний зөвлөгөө өглөө. Эрүүлжилтийн хувь 32,3. | |
| | 2.2.3 | Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх. | УТХО 26,0 | Нийт донорын тоо | 303 | 308 | Аймгийн хэмжээнд нийт 310 донор бүртгэлтэй байна. | 100 |
| | | | | Байнгын донорын эзлэх хувь | 61 | 65 | Нийт 310 донорын 201 буюу 68,0 хувийг байнгын донор эзэлж байна. | |
| | | | | Бүтээгдэхүүний хангалт/нэгж/ | 540 | 550 | 245 нэгж цус цусан бүтээгдэхүүний бүхэл цус цуглуулж, 10 нэр төрлийн 603 нэгж цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. | |
| | 2.2.4 | Өвөрмонголын Өөртөө Засах орны уламжлалтын эмчилгээ, оношилгооны эмч нарын багийн үзлэгийг орон нутагт зохион байгуулах. | - | Орон нутагт үзлэг зохион байгуулсан эсэх (Тийм 1, Үгүй 2) | 2 | 1 | 2023 оны10 дугаар сарын 23 –ны 01/ 1340 дугаартай аймгийн засаг даргын албан бичгийг Өвөр Монголын өөртөө засах орны Баяннуур аймгийн Ардын засгийн ордонд явуулсан бөгөөд зөвшөөрөл олгогдоогүй гэдэг шалтгаанаар ирээгүй болно. Дахин Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 02 –ны өдрийн 01/1385 албан бичгээр 2024 оны төлөвлөгөөнд оруулж хамтран ажиллах хүсэлтээ | ҮБ |
| | | | | Үзлэгт хамрагдсан иргэдийн тоо | 0 | 3500 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргүүлээд байна Хариу ирээгүй байна. Эрүүл мэндийн газраас шалтгаалсан асуудал байхгүй болно. | |
| | 2.2.5 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны тохижилт (тэргэнцэрт зориулсан үүдний хэсэг, хананы бариул, дуугүй хөтөч, тусгайлсан жорлон, дуут дохио гэх мэт)-ыг сайжруулах | УТХО 8,2 | Ээлтэй орчин бүрдүүлсэн эмнэлэг эрүүл мэндийн төвүүдийн ээлэх хувь | 95,0 | 98,0 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэхээр дуугүй хөтөч 6, дохионы хэлний самбар 12, бичгээр харьцах харилцааны самбар 6, 2 эрүүл мэндийн төвд хананы бариул, 3 суултуурын бариул, хөгжлийн бэрхшээлтэй иргэн орох замыг 2 эрүүл мэндийн төвд шинээр тус тус хийлгэсэн. Магадлан итгэмжлэлд орох 6 эрүүл мэндийн төвд, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж үйлчилгээний шалгуур үзүүлэлтийг 100 хувь хангасан байна. Ээлтэй орчин бүрдүүлсэн эмнэлэг эрүүл мэндийн төвүүдийн ээлэх хувь 98,2 | 100 |
| | 2.2.6 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл мэндийн үзлэгт хамруулах. | УТХО 0,5 | Үзлэгт хамрагдалтын тоо | 100 | 170 | Хөгжлийн бэрхшээлтэй 752 иргэнг үзлэгт хамруулснаас хэл засалд 120, хөгжлийн дэмжлэгт үйлчилгээнд 186, хөдөлгөөн засалд 210, хөдөлмөр засалд 189, сэтгэл зүйн засалд 4 гэр бүлийг тус тус хамруулсан. Хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүдэд эрт илрүүлэх үзлэгт Монголия Азиа Рийч байгууллагын дэргэдэх "Гэрэл-Өөд" ТББ-ын хамтран ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй 30 хүүхдийг үзлэгт хамруулснаас Хөдөлгөөн засал эмчилгээ 16 хүүхдэд, хөдөлмөр засал эмчилгээг 13 хүүхдэд хийлээ. Цахим сайтад хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан 10 мэдээлэл аман, зурган, боршуур, видео хэлбэрээр байршуулж, 15 сэдвээр 136 иргэнд сургалт зохион байгууллаа. Эхний 10 сарын байдлаар нийт 782 хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруууллаа. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эрүүлжилтийн хувь | 10.0 | 16,0 | Эрүүл мэндийн байгууллагаар тусламж үйлчилгээ авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний 16,2 хувь нь эрүүлжээд байна. | |
| | 2.2.7 | Өрх, сумын эрүүл мэндийн төвд 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг зохион байгуулах. (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/304, А/699, А/460 дугаар хамтарсан тушаал) | УТХО 1,2 | Үзлэгт хамрагдсан хүүхдийн хувь | 80,0 | 81,0 | БШУС, ЭМС,ХНХС-ын хамтарсан 2023 оны А/236, А/189, А/80 тоот “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөө батлах тухай” тушаалаар нийт 18, 36 сартай 846 хүүхэд хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамрагдахаас 18 сартай 324, 36 сартай 358 хүүхэд тус тус хамрагдсан нь үзлэг хамрагдах насны хүүхдийн 80,8%-ийг эзэлж байна. Үзлэгээр шинээр илэрсэн хөгжлийн хоцрогдолтой хүүхэд бүртгэгдээгүй байна. | 100 |
| | | | | Эрүүлжилтийн хувь | 25,0 | 33 | Үзлэгт хамрагдсан хүүхдээс 158 хүүхдэд өвчлөл илэрч эмчилэн эрүүлжүүлэх арга хэмжээг хийлээ. Эрүүлжилтийн хувь 45,0 | |
| | 2.2.8 | Сумдад 0-5 насны архаг хоол тэжээлийн дутагдалтай хүүхдийг эрүүлжүүлэх арга хэмжээ авах. | - | Чийрэгжүүлэлтэд хамрагдсан хүүхдийн тоо | 51 | 60 | 2024 онд хүүхдийг хоол тэжээлийн дутагдал, өсөлтийн хоцрогдлоос урьдчилан сэргийлэх, архаг хоол тэжээлийн дутагдалтай хүүхдийг эрүүлжүүлэх зорилгоор зуны чийрэгжүүлэлт, Эрүүл мэндийн яам, НҮБ-ын Хүүхдийн сангаас хамтран хэрэгжүүлсэн “Гамшгийн үеийн нялх, бага насны хүүхдийн хоол тэжээлийн дэмжлэг” төслийн хүрээнд чийрэгжүүлэн эрүүлжүүлэлтийг зохион байгууллаа. Адаацаг, Эрдэнэдалай, Сайнцагаан, Өлзийт, Луус, Хулд, Цагаандэлгэр, Дэрэн зэрэг 8 сумын 0-5 хүртлэх насны 68 хүүхдийг хамруулснаас 49 хүүхдийг хоол тэжээлийн архаг дутал болон өсөлтийн хоцрогдлоос сэргийлсэн. | 100 |
| | | | | Жин багатай болон хоол тэжээлийн дутагдал, өсөлтийн | 5 | 3 | Нийт 0-5 хүртлэх насны хүүхдийн хоол тэжээлийн мэдээг сар бүр авч нэгтгэхэд 1928 хүүхдэд өсөлт хоцрогдолтыг үнэлэх хэмжилт, үнэлгээ хийгдэж байна. Үнэлгээгээр өсөлт, хөгжилтийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хоцрогдолтой хүүхдийн тоо | | | хоцрогдолтой буюу жин бага, хоол тэжээлийн дутагдал, өсөлтийн хоцрогдолтой 3 хүүхдийг илрүүлж эрүүлжилт, чийрэгжүүлэлт хийсэн нь 0.2%-ийг эзэлж байна | |
| | 2.2.9 | Өсвөр насны хүүхдүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан сэтгэл зүйн зөвлөгөө өгч сургалт хийх. | УТХО 1,3 | Үзлэгт хамрагдалтын хувь | 15,0 | 10,0 | Өсвөр насны 10-19 насны 7738 хүүхдээс охид 3750 байгаа нийт хүүхдэд 48.5%-ийг эзэлж байна. Эхний 10 сарын байдлаар 812 охид өсвөр үеийн эмчийн тусламж үйлчилгээг авсан байгаа нь 21.6 хувийг эзэлж байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 220 охид хамрууллаа. Үзлэгээр амьсгалын замын өвчний учир 187, зүрх судасны өвчин 24, хоол боловсруулах замын өвчин 136, арьс, харшлын өвчин 36, тулгуур эрхтэн тогтолцооны өвчин 28, бөөр, шээс бэлгэсийн замын өвчний учир 109 тус тус илэрснийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг оношилгоонд хамрууллаа. Үзлэгт хамрагдалт 21.6 хувь байна. | 100 |
| | | | | Зөвлөгөө өгсөн болон сургалт хийсэн өсвөр үеийн хүүхдийн тоо | 1250 | 1100 | Нөхөн үржихүйн эрүүл мэнд сургалтыг Хүмүүнлэг, Эрдмийн далай цогцолбор сургууль, Мандал сургуулиудтай хамтран 6-12 дугаар ангийн сурагчдын дунд 10 удаагийн сургалтыг зохион байгуулж 1038 сурагчдыг хамрууллаа.<br>Ерөнхий боловсролын 6 сургууль болон Политехникийн коллежийн 14-18 насны сурагч, оюутнуудад "Өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэнд", "Нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Хорт зуршлаас сэргийлэх нь" сэдвүүдээр 22 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 1289 хүүхдийг хамруулан эрүүл мэндийн боловсрол олголоо.<br>Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд 12 удаагийн сургалтыг зохион байгуулж 746 сурагчдыг хамруулсан. Нийт 24 удаагийн сургалтаар 3073 сурагчдыг хамруулсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.2.10 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинетийг (урологи, андрологи) байгуулж үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэн үзлэгт хамруулах | УТХО 10,3 | Кабинет байгуулсан эсэх (Үгүй 2, Тийм 1) | 2 | 1 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Урологийн төрөлжсөн мэргэжлийн эмчийг бэлтгэж 2022 оны 6 сараас орон нутагт эрэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн бөөр, шээс дамжуулах доод замын урологийн нээлттэй хагалгааг нэвтрүүлэн эрэгтэйчүүдийн кабинетийг 2024 оны 3 дугаар сараас шинээр ажиллуулж эхлэсэн. | 100 |
